БАТЛАВ.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЭДИЙН ЗАСАГ, ДЭД БҮТЦИЙН АСУУДАЛ ХАРИУЦСАН НЭГДҮГЭЭР ОРЛОГЧ

Т.ДАВААДАЛАЙ

"АГРО-СИТИ" ДАГУУЛ ХОТЫН ХӨГЖЛИЙН ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ДААЛГАВАР

2025 оны 02 дугаар сарын 21 Дугаар:2025/.01 Улаанбаатар хот

1.	Зорилго	Нийслэл Улаанбаатар хотын хүн ам өсөлт, хүнсний ногоо болон бусад бүтээгдэхүүний эрэлт нэмэгдэж байгаатай холбогдуулан хүнсний аюулгүй байдал, импортын бүтээгдэхүүний хэмжээг бууруулах, хямд өртөгтэй эрүүл хүнсээр хангах, инноваци шингэсэн үйлдвэрлэл, ажлын байрыг нэмэгдүүлэх зорилгоор байгуулж байгаа Агро-Сити дагуул хотын нийгэм, эдийн засаг, үйлдвэрлэл, үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлийг оновчтой төлөвлөж, хот байгуулалтын баримт бичиг боловсруулах.
2.	Үндэслэл	- Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого; - Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор батлагдсан "Шинэ сэргэлтийн бодлого"; - Монгол Улсын Их Хурлын 2024 оны 64 дүгээр тогтоолоор баталсан 'Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал"; - Монгол Улсын Их Хурлын 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн "Хот байгуулах тухай" 72 дугаар тогтоол; - Улсын Их Хурлын 2022 оны "Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай" 36 дугаар тогтоол; - Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор баталсан "Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр"; - Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн хуралдааны 2 дугаар тэмдэглэлээр дэмжигдсэн Нийслэл Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний төсөл; - Монгол Улсын Засгийн газрын "Эдийн засгийн тусгай бүс байгуулах тухай" 2024 оны 220 дугаар тогтоол; - Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 267 дугаар тогтоол "Геодезийн солбицол, өндөр, тусгагийн нэгдсэн тогтолцоог шинэчлэн батлах тухай"; - Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 24/08 дугаар тогтоолоор батлагдсан "Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр" ;

		- Нийслэлийн Засаг даргын 2025 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн "Эрх шилжүүлэх тухай" А/107 дугаар захирамж; - холбогдох бусад.
3.	Байршил, эдийн засаг, нийгэм хөгжлийн байдал	**Одоогийн байдал:** "Агросити" дагуул хот нь Сонгинохайрхан дүүргийн 21 дүгээр хорооны нутаг дэвсгэрт 24294,7 га талбайд байрлалтай, "361-ын гарам, Рашаант, Жаргалант зэрэг бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан суурьшлын бүсүүдтэй. Дагуул хотын нутаг дэвсгэрийн 9000 га талбайд Засгийн газрын 2024 оны 220 дугаар тогтоолоор "Эдийн засгийн тусгай бүс"-ийг байгуулсан. Одоогийн байдлаар тус хотын суурьшлын бүсэд 2689 өрхийн 7652 хүн оршин оршин суудаг. **Инженерийн бэлтгэл арга хэмжээ:** Нэгдсэн үерийн усны шугам сүлжээ байхгүй, хэсэгчлэн хийсэн далан сувагтай. Авто замын доогуур үерийн суваг хийгдсэн. <u>Цахилгаан хангамж:</u> Цахилгаан хангамжийн шугам сүлжээ хэвийн <u>Дулаан хангамж:</u>Бие даасан эх үүсвэртэй <u>Мэдээлэл холбоо:</u>Монгол наадам цогцолбор, төмөр замын шугам сүлжээний сүлжээ ажилладаг <u>Усан хангамж:</u> Ус хангамжийн шугам сүлжээний нэгдсэн шугам сүлжээ байхгүй. Аж ахуйн нэгж , иргэд хувийн худаг, зөөврийн худгаас цэвэр усаа хэрэглэдэг. <u>Ариутгах татуурга:</u>Нэгдсэн шугам сүлжээ байхгүй. Аж ахуйн нэгж бүр хувийн байгууламж ашигладаг.
4.	Хамрах хүрээ, газар нутгийн хэмжээ, хүн ам	**Төлөвлөлтийн хязгаар, хамрах хүрээ:** - Улаанбаатар хотын баруун хойд хэсэгт Сонгинохайрхан дүүргийн 21 дүгээр хороо /361-н гарам, Рашаант, Жаргалант/-ны 24294.7 га /Төлөвлөлтийн хамрах хүрээ Хавсралт 1./ **Хүн ам:** - Одоогийн- 2689 өрхийн 7652 хүн амтай; - Төлөвлөлтөөр- 30,000 хүртэл хүн амтай байхаар тооцох.
5.	Зураг төсөл боловсруулах эх үүсвэр	Нийслэлийн 2025 оны төсөв- 2,332,700,000 төгрөг /Хоёр тэрбум гурван зуун гучин хоёр сая долоон зуун мянга/
6.	Захиалагч байгууллага	Нийслэлийн Засаг даргын Тамгын газар; Хот байгуулалт, хотын стандартын газар.
7.	Боловсруулах байгууллага	Хот байгуулалтын тухай хуулийн 11.2-т заасны дагуу хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тусгай зөвшөөрөл авсан, сонгон шалгаруулалтаар шалгарсан аж ахуйн нэгж, байгууллага.
8.	Зөвшөөрөлцөх байгууллага	**Батлах байгууллага:** Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал **Зөвшөөрөлцөх байгууллага:** - Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам;

		- Нийслэлийн Засаг даргын Тамгын газар; - Агро-сити эдийн засгийн тусгай бүсийн Захирагчийн ажлын алба; **Санал авах байгууллага:** - Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам; - Эдийн засаг, хөгжлийн яам; - Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлагууд; - Инженерийн дэд бүтцийн шугам сүлжээний хангагч байгууллагууд; - Төлөвлөлтийн тодорхой үе шатуудад олон нийтийн хэлэлцүүлэг, зөвлөгөөн зохион байгуулах; - Хот байгуулалт, архитектурын мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх; - Шинжлэх ухаан, техник, технологийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх; - ерөнхий төлөвлөгөөний баримт бичгийг магадлалын нэгдсэн дүгнэлт гаргуулах.
9.	Боловсруулах ажлын үе шат	Агросити дагуул хот болон эдийн засгийн тусгай бүсийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулах үйл ажиллагааг дараах үе шатны дараалаар гүйцэтгэнэ. Үүнд: а/ хот байгуулалтын суурь судалгаа, үнэлгээ дүгнэлт; б/ хот байгуулалтын иж бүрэн үнэлгээ; в/ техник эдийн засгийн үндэслэл; г/ төлөвлөлтийн үндсэн шийдэл, хэтийн төлөв; д/ хэрэгжүүлэх арга хэмжээ.
10.	Боловсруулах хугацаа	Захиалагч, гүйцэтгэгч талуудын хооронд гэрээ байгуулснаас хойш 180 хоногийн хугацаанд боловсруулна. **Эхний тайлан: /60 хоногт гүйцэтгэнэ/** - одоогийн байдлын судалгаа, байр зүйн зураглал, инженер геологийн судалгаа дуусан байх, одоогийн байдалд үнэлэлт дүгнэлт хийж судалгааг нэгтгэн боловсруулсан байх; - хот байгуулалтын иж бүрэн үнэлгээ хийсэн байх; - байгаль орчны төлөв байдлын үнэлгээ хийсэн байх; - гадаад дотоод орчны шинжилгээ хийсэн байх; - төлөвлөлтийн хязгаарт байрлаж байгаа төсөл, хөтөлбөр, төлөвлөгдсөн барилга байгууламжуудын хүчин чадлыг тодорхойлсон байх; - техник эдийн засгийн үндэслэл /2-оос доошгүй хувилбараар тооцох/; - эхний шатны тайланг хот төлөвлөлтийн асуудал хэлэлцэх зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн байх. **Дундын тайлан: /75 хоногт гүйцэтгэнэ/** - эхлэлийн тайланд өгсөн саналыг тусгаж төлөвлөлтийн үе шатанд тавигдах шаардлагын дагуу төлөвлөлтийг гүйцэтгэсэн байх; - техник эдийн засгийн үндэслэл магадлалын нэгдсэн дүгнэлт гаргуулсан байх; - төлөвлөлтийн шийдэл, хэтийн төлөв боловсруулсан байх;

		- төлөвлөлтийн шийдлийг инженерийн дэд бүтцийн ашиглагч байгууллагуудтай зөвшилцөх /ЦДҮС ТӨХК, УБЦТС ТӨХК, УСУГ ОНӨААТҮГ, МХС ТӨХК/; - Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, харьяа газар болон Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын дунд хамтарсан уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулж санал, зөвлөмж авах, - төлөвлөлтийн шийдлийг олон нийтэд танилцуулж санал авч, хэлэлцүүлэг хийх; - дундын шатны тайланг хот төлөвлөлтийн асуудал хэлэлцэх зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн байх. **Эцсийн тайлан: /45 хоногт гүйцэтгэнэ/** - төлөвлөлтийн шийдлийг эцэслэн боловсруулсан байх; - хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулсан байх; - хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардлагатай эдийн засаг, хөрөнгө оруулалтын тооцоо хийж, эх үүсвэрийг тодорхойлсон байх; - дундын тайланд өгсөн санал, зөвлөмжийг тусган эцсийн байдлаар иж бүрэн хүлээлгэн өгөх. **Магадлалын нэгдсэн дүгнэлт** Эрх бүхий байгууллагаар Магадлалын нэгтгэсэн дүгнэлт гаргуулах. /Ажил гүйцэтгэх 180 хоногт ерөнхий төлөвлөгөөний магадлалын нэгдсэн дүгнэлт гаргуулах хугацаа ороогүй болно/
11.	Ашиглах материал	Хууль, тогтоомж: - Монгол Улсын хэмжээнд хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль тогтоомж; - Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль; - Монгол Улсын Нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хууль; - Хот байгуулалтын тухай хууль; - Хөгжлийн бодлого, төлөвлөлт түүний удирдлагын тухай хууль; - Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хууль; - Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль; - Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль; - Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хууль; - Газрын багц хуулийн шинэчилсэн найруулга; - Геодези, зураг зүйн тухай хууль; - Барилгын тухай хууль; - Усны тухай хууль; - Эрчим хүчний тухай хууль; - Эрчим хүчний хэмнэлтийн тухай хууль;

		- Инновацийн тухай хууль; - холбогдох бусад хууль. Норм, нормативууд: - Хот, тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм (БНбД 30-01-04); - Хот, суурины хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах аргачилсан заавар (УББ 11-202-00); - Хот, суурины дэвсгэр газарт хот байгуулалтын иж бүрэн үнэлгээ өгөх аргачилсан заавар (УББ 30-201-09); - Барилга байгууламжийн инженер-экологийн судалгаа (БД 11-102-07); - Үйлдвэрийн газрын барилгажилтын ерөнхий төлөвлөгөө (БНбД 30-02-07); - Хот суурины гудамж, зам төлөвлөлт (БНбД 32-01-04); - Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, зөвшилцөх, магадлал хийх дүрэм; - Байр зүйн болон дэвсгэр зургийн загвар сан, таних тэмдгийн стандарт MNS 6702:2017 стандарт; - Газар зүйн мэдээллийн стандарт MNS 6925:2021; - MNS6056:2009 Явган хүн болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан замыг төлөвлөх заавар; - UCS 1001C Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй дэд бүтцийн зураг төсөл; - UCS 0501A Үерээс хамгаалах, борооны ус зайлуулах байгууламжийг төлөвлөх удирдамж; - UCS 0801A Хот суурин газрын цэцэгжүүлэлт, ногоон байгууламжийн төлөвлөлт; - UCS 0901B Явган хүний зам, талбайн төлөвлөлт, хучилт угсралтад тавих ерөнхий шаардлага; - UCS 0902B Тээврийн хэрэгслийн ил зогсоолыг төлөвлөх, байгуулахад тавих ерөнхий шаардлага; - UCS 0903B Унадаг дугуйн замын төлөвлөлт, хучилтад тавих ерөнхий шаардлага; - UCS 1902A Гэрэлтүүлэх төхөөрөмжийг төлөвлөх, байрлуулах, суурилуулах удирдамж.
12.	Ажлын иж бүрдэл	Хөгжлийн ерөнхий төлөвлөгөө нь дараах 5 ботиос бүрдсэн байна. Үүнд: I.Одоогийн байдал, суурь судалгаа; II.Техник эдийн засгийн үндэслэл; III.Тайлбар бичиг; IV.Зураглалын материал; V.Хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө. **Техник эдийн засгийн үндэслэл:** - төслийн нөхцөл байдлын шинжилгээ /Орчны болон эрсдэлийн шинжилгээ, эрэлт, нийлүүлэлтийн шинжилгээ/ - төслийн техник технологийн шийдэл,

		- төсөл хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө, - санхүү, хөрөнгө оруулалтын тооцоо; - 2-оос доошгүй хувилбартай тооцох. **Зураглалын материал:** <u>Суурь, судалгааны зураглал</u> - зургийн жагсаалт, тайлбар бичиг; - байршлын схем; - орчны тойм; - байр зүйн дэвсгэр зураг М1:5000; - байр зүйн дэвсгэр зураг /номинклатур/ М1:2000; - Засаг захиргаа, төрийн үйлчилгээ, олон нийтийн барилга /хороо, цагдаагийн хэсэг/ - хүн амын нягтрал; - барилгажилтын судалгаа; - барилгажилтын нягтрал; - хүн амын нягтрал; - газар ашиглалтын байдал; - газар ашиглалтын зориулалт; - газар ашиглалтын эрхийн хэлбэр; - нийгмийн дэд бүтэц, үйлчлэх хүрээ; - ногоон байгууламж, тохижилт; - түүх, соёлын дурсгалт барилга байгууламж, нүүлгэн шилжүүлэх байршил; - гудамж замын сүлжээ; - нийтийн тээврийн сүлжээ; - хот суурин газрыг дахин хөгжүүлэх төслийн судалгаа; - төсөл, хөтөлбөрийн судалгаа; - инженерийн дэд бүтцийн судалгаа. Үүнд: - дулаан хангамж; - ус хангамж, ариутгах татуурга; - цахилгаан хангамж; - холбоо мэдээлэл; - инженерийн бэлтгэл арга хэмжээ; - өндөржилт, улаан шугам; - үерийн хамгаалалт, далан суваг; <u>Төлөвлөлтийн зураглал</u> - зургийн жагсаалт, тайлбар бичиг - төлөвлөлтийн үзэл баримтлал; - хот байгуулалтын бүсчлэл; - ерөнхий төлөвлөгөө /батлагдах/; - архитектур орон зайн төлөвлөлт, барилгажих төрх; - төлөвлөлтийн үе шат; - гудамж, замын сүлжээ; - авто замын өндөржилт, улаан шугам;

		- дугуйн зам, явган замын сүлжээ; - нийгмийн дэд бүтцийн төлөвлөлт; - Засаг захиргаа, олон нийтийн барилга байгууламж; - ногоон байгууламж, тохижилт, цэцэрлэгжүүлэлт; - түүх соёл, аялал жуулчлал, амралт, аялал зугаалгын бүсийн , орон зайн төлөвлөлт; - нийтийн тээврийн сүлжээ; - ачаа тээврийн сүлжээ; - хог хаягдлын менежмент; - гамшгийн менежмент; - инженерийн бэлтгэл арга хэмжээ, өндөржилт, улаан шугам; - инженерийн дэд бүтцийн нэгдсэн төлөвлөлт; - дулаан хангамжийн төлөвлөлт; - ус хангамж, ариутгах татуургын; - цахилгаан хангамжийн төлөвлөлт; - холбоо мэдээллийн сүлжээ төлөвлөлт; - газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэх эдэлбэр газрын судалгаа /төлөвлөгдсөн барилга байгууламж, нийгмийн дэд бүтэц, авто зам, авто замын улаан шугам, инженерийн дэд бүтцийн нөлөөлөлд өртсөн/; - ерөнхий төлөвлөгөөний харагдах байдал /3D зураг/; - төлөвлөлтийн онцлогийг харуулсан анимэйшн- 2ш /Дагуул хотын төлөвлөлт, Эдийн засгийн тусгай бүсийн төлөвлөлт/ **Тайлбар бичиг:** - зураг төсөл боловсруулах үндэслэл, аргачлал; - өнөөгийн байдлын судалгаа, үнэлгээ, дүн шинжилгээ, хөгжлийн төсөөлөл; - хүн ам, эдийн засаг, нийгмийн хөгжлийн хэтийн төлөв; - төлөвлөлтийн үндсэн шийдэл, эхний ээлжийн төлөвлөлт; - хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, шаардагдах хөрөнгө оруулалт; - техник, эдийн засгийн нэгдсэн үзүүлэлт. **Хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө** - хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хүрээнд хэрэгжих томоохон төсөл, арга хэмжээний байршлын бүдүүвч зураг; - төлөвлөлтийн үе шатны зураглал; - төлөвлөлтийн эхний ээлжид хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний байршлын бүдүүвч зураг; - хэрэгжүүлэх арга хэмжээний зөвлөмж. **Товч танилцуулга:**

		- хэвлэлийн эх бэлтгэл, цаасны формат, /сонголтоор/ - хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний хураангуй; - хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хураангуй; - хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний онцлог давуу талыг тусгасан хурлын тараах материал; - олон нийтэд зориулсан тараах материал/брошюр/. **Хэвлэмэл материал** - хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлын эхлэл, дундын тайлангийн бичиглэлийн баримт бичгийг А4, зураглалын баримт бичгийг А2 форматаар 1% хүлээлгэн өгөх; - эцсийн тайлангийн бичиглэлийн баримт бичгийг А4, зураглалын баримт бичгийг А1 форматаар 1% хүлээлгэн өгөх; - магадлалын нэгтгэсэн дүгнэлт гаргуулж эрх бүхий байгууллагаар батлуулсан бичиглэлийн баримт бичгийг А4, зураглалын баримт бичгийг А1 форматаар тус бүр 5%, цаасан хэлбэрээр хүлээлгэн өгөх. **Тоон баримт бичиг** <u>Бичиглэлийн баримт бичиг</u> - ажлын файл /*.doc, *.pdf, *.xlsx /; - батлагдсан баримт бичиг скайнер /*.pdf, *.jpg/. <u>Зураглалын баримт бичиг</u> - ажлын файл/*.dwg, *.shp, *.skp, lumion, *.max, *.cdr, *.jpg /; - орон зайн өгөгдлийн санг MNS 6925:2021 стандартын дагуу үүсгэх; - батлагдсан баримт бичиг скайнер /*.jpg, *.pdf/. <u>Товч танилцуулга</u> - хурлын танилцуулга /*.ppt/; - хурлын тараах материал /*.doc, *.pdf,/ ; - төлөвлөлтийн онцлогийг харуулсан анимэйшн 3 минутаас багагүй /*.mp4, 1080HD/. Зураг төслийг хот байгуулалтын мэдээллийн санд хүлээж авахад тавигдах шаардлага /Хавсралт-2-ын дагуу хийх/
13.	Шийдвэрлэх үндсэн асуудлууд	**Төлөвлөлтийн үе шат:** Хот байгуулалтын баримт бичгийг боловсруулахдаа урт, дунд, богино хугацаанд төлөвлөнө. Үе шатны төлөвлөлт, төлөвлөгөөг боловсруулахдаа Монгол улсын хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль болон холбогдох хууль эрх зүйн баримт бичгийг мөрдлөг болгоно. **Орон зайн төлөвлөлт:** - Хот байгуулалтын тухай хуулийн дагуу нутаг дэвсгэрийн бүсчлэлийг гаргаж, зөвшөөрөгдөх үйл ажиллагааг тодорхойлох;

		- Улаанбаатар хотын хөгжлийн үзэл баримтлалтай уялдуулан барилгажилтын дүр төрх, гудамжны дэлгээсийг гаргах; - хот байгуулалтын үйл ажиллагаа, барилгажилтыг хориглох, хязгаарлах, дэмжих бүсийг тодорхойлох; - барилгажилтын талбайн үүрэг, зориулалт барилгын өндрийн дээд хязгаарыг тодорхойлох; - хүн ам, барилгажилтын нягтралыг норм дүрэмд нийцүүлэн төлөвлөх; - барилга байгууламжийг төлөвлөхдөө орчин үеийн дэвшилтэд технологийг судлан, байгаль орчинд ээлтэй шийдлийг тусгах. - дагуул хотын 9000 га талбайд нарийн ногоо, далайн гаралтай бүтээгдэхүүн, мөөг, хөнгөн үйлдвэрлэлийн чиглэлийн Эдийн засгийн тусгай бүсийн ерөнхий төлөвлөлтийг гаргах; - эдийн засгийн тусгай бүсийн төлөвлөлтөд гадаад дотоодын хөрөнгө оруулалтыг татах таатай орчныг бүрдүүлсэн, экспорт импортыг дэмжих, нарийн ногоо, мөөг, далайн гаралтай бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийг хөгжүүлэх, техник технологийг нутагшуулах, эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэх төлөвлөлтийн зарчмуудыг тусгасан байх; - суурьшлын бүсийн орон зайн оновчтой төлөвлөлтийг дагуул хот болон дагуул хотод байгуулагдах эдийн засгийн тусгай бүсийн бизнесийн өсөлттэй холбон төлөвлөх; - хөдөө аж ахуй, газар тариалангийн чиглэлээр гадаадын улсуудад байгуулж хөгжүүлсэн хотын туршлагыг судлан, өөрийн орны онцлогт тохируулан нутагшуулах төлөвлөлтийг боловсруулах; - биотехнологи, хүнсний инноваци, газар тариалангийн дижитал шийдлүүдийг төлөвлөлтөд тусгах; - олон улсын болон, орон нутаг, хотын чанартай авто болон төмөр зам, ложистикийн нэгдсэн сүлжээтэй нягт уялдуулан төлөвлөх; **Газар зохион байгуулалт:** - иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудын өмчлөл, эзэмшил, ашиглалтад байгаа газрын судалгаа гаргаж зориулалт, хугацаагаар нь ангилах; - зөвшөөрөлгүй газар өмчилж, эзэмшиж, ашиглаж буй болон өмчлөл, эзэмшил, ашиглах газрын хэмжээнээс илүү талбай хашиж ашиглаж буй иргэн аж ахуй нэгж байгууллагын судалгаа гаргах; - газар ашиглалтын талбайн балансыг одоогийн байдал, төлөвлөлтийн байдлаар нарийвчлан гаргах; - ундны усны эх үүсвэрийн хамгаалалт, хориглолт, хязгаарлалтын бүс, өндөржилт, үерийн далан суваг, байгалийн жалга, борооны ус, гадаргын ус зайлуулах шугам сүлжээ, хөрсний ус зайлуулах системийн хамгаалалтын бүс болон инженерийн дэд бүтцийн

		шугам, сүлжээ, хамгаалалтын бүсэд орсон эдэлбэр газрын судалгааг гаргах; - газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлтийн үнэлгээг тооцох. **Гудамж, замын сүлжээ:** - одоо байгаа авто замын сүлжээний судалгааг гаргах, хүчин чадал, замын өргөн, эгнээ, нийт урт, эрчмийн судалгаа, авто замын хүрэлцээ төрлөөр ангилах, уулзвар, гүүр болон нүхэн гарцын байршил, хүчин чадлыг тодорхой гаргах; - эдийн засгийн тусгай бүсээс хангах хүнсний бүтээгдэхүүний хадгалалт, тээвэрлэлтийн хувилбарт шийдлийг гаргах; - Шижирийн даваany шороон замыг сайжруулсан зам болгох шийдэл боловсруулах, өртөг тооцох; - гүнтийн авто замыг нүхэн гарцаар төлөвлөх, өртөг тооцох; - гадна зам талбайн хөдөлгөөнийг гол гудамж, замын хөдөлгөөнтэй уялдуулж, гудамж замын нэгдсэн өндөржилтийн төлөвлөлттэй уялдуулан төлөвлөх; - гүүр хоолойг төсөллөхдөө удаан хугацаагаар эдлэгдэх нөхцлийн хангуулсан байх, хүрээлэн буй байгаль орчныг хамгаалах арга хэмжээг авсан байх; - тээвэр логистикийн чиглэлд Улаанбаатар хотын зүүн бүстэй шууд холбогдох хурдны замын төлөвлөж, хөрөнгө оруулалтыг тооцох. - нийслэл хотын хүн амын өсөн нэмэгдэх эрэлт, нийлүүлэлтэд нийцүүлэн авто машины хөдөлгөөний эрчмийг тооцон гудамж замын замын зэрэглэл, хүчин чадлыг тооцон нэгдсэн сүлжээ байдлаар төлөвлөх; - нийтийн тээврийн зогсоол болон эцсийн зогсоолын орон зайн, байршлыг тогтоож норм дүрмийн дагуу төлөвлөх; - аялагчдад зориулсан авто зогсоолын байршил, дугуйн зам, явган чиглэлийг тодорхойлох; - уулзвар төлөвлөлтийг мэргэжлийн программ хангамжаар тооцоолон хийх, гэрлэн дохион зохицуулалтай, зохицуулалтгүй уулзвар төлөвлөлтийг ЗХУТ, Тээврийн цагдаагийн алба, НЗХГ-тай зөвшилцөн баталгаажуулах; - хатуу хучилттай авто зам төлөвлөх ба хучилтын бүтээцийг тооцоогоор хийх шаардлагатай; - авто замын төлөвлөлтийг дүүргийн хэмжээнд хийгдсэн нэгдсэн өндөржилт төлөвлөлттэй уялдуулан гүйцэтгэж, авто замын хучилтын төрлийг нарийвчлан гаргах; - авто замын төлөвлөлтөд хөндлөн гарч буй үерийн хамгаалалтын байгууламжийн гаргалгааг ус зүйн тооцоонд үндэслэн төлөвлөх; - инженерийн шугам сүлжээний нэгдсэн төлөвлөлттэй уялдуулан авто замын доогуурх нэвтрэх суваг төлөвлөх. - төмөр замын трасстай уялдуулах. **Эдийн засаг:**

		- эдийн засгийн салбар, чиглэлүүд, тэдгээрийн нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэл, нэмүү өртөг бий болгож буй байдал, ажил эрхлэлт, ажлын байрны хангамжийг нарийвчилсан судалгаа хийх; - аж ахуйн нэгжийн бизнесийн орчин тогтвортой өсөлттэй байхаар судалгаа хийж, бие даан хөгжих чадвартай дагуул хотын татварын бодлогыг тооцох; - бизнесийн зарчим, загварын төлөвлөлтийг гаргах; - шилжилт хөдөлгөөний хэтийн тооцоолол хийх; - эдийн засгийн тусгай бүсээс хангах боломжтой хүнсний бүтээгдэхүүний нэр төрөл, хангамж, бүтээгдэхүүний хэрэгцээг Монгол улсын хүн амын өсөлттэй уялдуулан тооцох; - төлөвлөлтийг хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг тодорхойлох, - тухайн нутаг дэвсгэрт хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн хөгжлийн боломжийн судалгаа, таатай орчинг бүрдүүлэх шийдлийг боловсруулах, - хөдөө аж ахуй тэр дундаа хүлэмжийн аж ахуйн чиглэлийн сургалт-үйлдвэрлэлийн болон хүнсний хяналтын лаборатор, бизнес инкубатор төв байгуулах хувилбарт шийдлийг гаргах; - хөрөнгө оруулалт, бизнесийн орчин, ажил эрхлэлт, орлогын түвшин цалин хөлсний судалгаа хийх; - хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийг ач холбогдлоор нь эрэмбэлэн хэрэгжүүлэх цаг хугацаа, дараалыг тодорхойлох; - төр хувийн хэвшлийн уялдааг ханган шийдэл боловсруулах. **Нийгмийн дэд бүтэц:** - одоо байгаа засаг захиргаа, төрийн байгууллагуудын бүтэц, байршил, үйлчлэх хүрээ, хүчин чадал, хүрэлцээг судлах; - сургууль, цэцэрлэг, эмнэлэг, иргэдийн чийрэгжих спорт талбайн байршил, хамрах хүрээ, хүчин чадлыг тодорхойлох; - шинээр барих сургууль, цэцэрлэгийн барилгын байршил, судалгааг гаргаж, хүчин чадлыг тодорхойлох; - олон нийтийн зориулалттай барилга байгууламжийн судалгаа гаргаж зориулалт, хүчин чадлыг тодорхойлох; - нийгмийн дэд бүтцийн барилга байгууламжийг гудамж замын сүлжээ, цэцэрлэгжилт, суурьшлын бүсүүдтэй уялдуулан төлөвлөх; - нарийн ногоо, далайн бүтээгдэхүүний бие даасан эх үүсвэртэй хүлэмжийн аж ахуйн үйлдвэрлэлийг судалж тусгах; - дагуул хот, тусгай бүсийн шилжилт хөдөлгөөн, хүн амын өсөлт, бизнес эрхлэгчдэд нийцүүлэн бага, сургууль цэцэрлэгийн цогцолбор төлөвлөх. **Орон сууцны хангамж:** - одоогийн орон сууцны хангамжийн судалгаа гарах;

		- ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган шинээр барих төсөлтэй уялдуулж, цаашид хэрэгжүүлэх менежментийг тодорхойлох; - төлөвлөлтийг 24-48 соге шилэн кабелыг тарааж суурилуулахаар төлөвлөх; - орон сууцны олон төрөлт /ногоон, түрээсийн, төлбөрт нийцсэн/ хэлбэрийг төлөвлөх; - орон сууц, олон нийтийн барилга байгууламжийн байршил зориулалтыг оновчтой төлөвлөх; - орон сууцны хангамж, бий болох ажлын байр, өнөөгийн болон хэтийн эрэлт нийлүүлэлтийн харьцаанд үндэслэн тооцох; - одоогийн орон сууцны хорооллуудын нийгмийн дэд бүтэц, үйлчилгээний хүртээмжийг сайжруулах, хотын чанартай авто зам дагуу орон сууцны барилгуудын доод давхруудыг үйлчилгээ ажлын байр байх хувилбарыг судалж төлөвлөх. - дохиолол хяналтын нэгдсэн сүлжээ төлөвлөх; - гамшгийн үеийн зарлан мэдээлэх систем төлөвлөх; - хөнгөн үйлдвэрлэл, барилгын материалын худалдааны замыг суурьшлын бүсээр дамжин өнгөрөхгүй байдлаар төлөвлөх, тооцоолол хийх; **Хот орчмын аялал жуулчлал:** - тухайн нутаг дэвсгэрт одоо байгаа аялал жуулчлал, амралтын газруудын чиглэл, төрлүүдээр ангилж, хүчин чадлын судалгаа гаргах; - гадаад, дотоодын нийт зорчигчдын тоо, жилд үйлчлүүлэх жуулчдын эрэлт нийлүүлэлтийн судалгааг гаргах; - одоо үйл ажиллагаа эрхэлж буй амралт, аялал жуулчлалын газруудын үйлчилгээний үнэ тарифийн судалгаа гаргаж, эдийн засагт нөлөөлөх байдалд үнэлэлт, дүгнэлт өгөх; - "Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө"-ний төсөлд тусгагдсан аялал жуулчлалын маршруттай уялдуулах; - нутаг дэвсгэрийн амралт, аялал жуулчлалын нөөц ашиглалтын өнөөгийн хэлбэр, бодит байдал, газар нутгийн онцлогт тулгуурлан амралт, аялал жуулчлалын орон зайн хилийн зааг, чиглэл, төрлүүдийг тодорхойлж, хэрхэн хөгжүүлэх шийдэл боловсруулах; - жилийн турш байнгын үйл ажиллагаатай аялал жуулчлал хөгжих нөөц боломжийг судалж төлөвлөлтийн шийдэл боловсруулах; - гадаад дотоодын нийт зорчигчдын тоо, жилд үйлчлүүлэх жуулчдын хүчин чадлыг одоо байгаа болон төлөвлөлтийн байдлаар тооцож тодорхойлох; - байнгын ажлын байр бий болгох нөхцөлийг бүрдүүлэх төлөвлөлтийн шийдлийг боловсруулах; - жуулчид, амрагчид, гэр бүлийнхэнд зориулсан өөрсдийн хувийн сууц ашиглан түр амрах, отоглох, талбайнуудын

		байршлыг зааж хүчин чадал, үйл ажиллагааны зохицуулалтын механизмыг тусгах; - жуулчдын үзвэр үйлчилгээ, соёлын барилга байгууламжийг аялал жуулчлалын нэгдсэн төлөвлөлттэй уялдуулан өндөрлөг цэгүүдийн байршлыг тодорхойлж төлөвлөлт хийх; **Түүхийн ба соёлын дурсгалт зүйлсийг хамгаалах төлөвлөлт** - соёлын өв, түүхийн дурсгалт газруудын байршил, одоогийн нөхцөл байдлын судалгаа хийх; - дахин давтагдашгүй хийцлэлтэй, улс, хот, дүүргийн түүхийг хадгалсан барилга, байгууламж, дурсгалт газруудын судалгаа гаргах; - археологи, палеонтологийн чиглэлээр өмнө хийгдсэн судалгаа, шинжилгээний ажлыг судалж, олдворуудын байршил болон хамгаалалтыг бүсийг тогтоох; - хот төлөвлөлтөд түүх-соёлын дурсгалт газрыг хадгалах-хамгаалах, шинэчлэн сэргээн засварлах, шинээр барьж байгуулах төлөвлөлтийг тусгах. **Ногоон байгууламж:** - нэг хүнд ногдох ногоон байгууламжийн хэмжээг тодорхойлох; - цэцэрлэгжүүлэлт, ногоон байгууламжийг хүн амын ажиллаж амьдрахад тохиромжтой гоо зүй, ариун цэвэр-эрүүл ахуйн нөхцөлийг хангасан, хотын орон зайн бичил уур амьсгалын тааламжтай орчинг бий болгож хүний үйл ажиллагааны элдэв хортой нөлөөллөөс хамгаалах, барилгажсан нутаг дэвсгэрийн архитектур-орон зайн зохиомжийг сайжруулсан байхаар тооцож төлөвлөх; - ногоон байгууламжийг дүүргийн болон хорооллын чанартай цэцэрлэгт хүрээлэн, амрах бичил цэцэрлэг, тусгай хамгаалалттай газар нутгийн ногоон байгууламж зэргээр ангилах; - цэцэрлэгжилт, ногоон байгууламжийг төлөвлөхдөө нийтийн хэрэгцээний, хязгаарлагдмал зориулалттай, тусгай зориулалттай гэсэн үндсэн ангиллыг баримтлах; - хүн амын тооноос хамааруулан норм дүрмийн дагуу ногоон байгууламж, нийтийн эзэмшлийн зам талбайн балансыг гаргах; - аялагчдад зориулсан ногоон байгууламжийн хүртээмж, хүчин чадал, байршлыг тодорхойлох. **Худалдаа үйлчилгээ:** - тухайн нутаг дэвсгэрийн хүн амын хэрэгцээг хангах худалдаа үйлчилгээний цогцолборуудыг төлөвлөх; - ухаалаг хүлэмжийн аж ахуй түүнийг даган хөгжих боломжтой кластер үйлдвэрүүд, худалдаа, үйлчилгээг төлөвлөх, хувилбарт нөхцөлийг дэвшүүлэх; - тухайн нутаг дэвсгэрийн хүн амын үзвэр үйлчилгээ, олон нийт, соёлын барилга байгууламжийг үйлчлэх хүрээг холбогдох нормын дагуу тооцож төлөвлөх. **Жижиг дунд үйлдвэрлэл:**

		- хүн амын тоо, ажлын байрны хэрэгцээ шаардлагыг тооцож, өрхийн аж ахуй, жижиг дунд үйлдвэрлэлийн төрөл, байршлыг үйлчлэх хүрээгээр оновчтой төлөвлөх; **Ачаа тээвэр:** - худалдаа, үйлчилгээ, үйлдвэрийн түүхий эдийн хангамжийг нийлүүлэх ачаа тээврийн авто замын төлөвлөлтийг тодорхойлох; - Улаанбаатар хотын логистик төлөвлөлт, тээвэрлэлт хийх түгээлтийн системтэй төлөвлөлтийг уялдуулах; **Хог хаягдал:** - одоо байгаа хог хаягдлын менежментийг судлах, давуу болон сул талуудыг тодорхойлох; - хог хаягдлын цэгүүд болон төвлөрүүлэх газруудын байршлыг тодорхойлох; - эдийн засгийн тусгай бүсийн үйлдвэрлэл үйл ажиллагааны чиглэлтэй уялдуулан хог хаягдлын менежментийг удирдах, төлөвлөх, дахин ашиглалт, ухаалаг системийн хувилбарт шийдлийг дэвшүүлэх; - амралт, аялал жуулчлалын бүсийн онцлогт тохирсон байгальд хор хөнөөлгүй хог хаягдлын системийг бий болгох шийдлийг тусгах; **Гамшгийн менежмент:** - гамшгийн менежмент болон онцгой байдлын газар, гал унтраах анги, усны гидрант, аюулын дууд дохио, хорогдох байр, түр цуглах талбай, маршрутыг төлөвлөх; - гамшгийн аюулд өртөх магадлалтай газар нутаг болон айл өрх, эдэлбэр газарт цаашид авах арга хэмжээг тодорхойлж, төлөвлөх; Гамшгийн эрсдэл гарч болох аюултай газрыг тодорхойлж, хориглох, хязгаарлах нөхцөлүүдийг тусган төлөвлөх.
14.	Инженерийн байгууламж, шугам сүлжээний эх үүсвэр, хангамж	**Инженерийн бэлтгэл арга хэмжээ:** - Улаанбаатар хотын үерийн хамгаалалтын далан суваг, хөрсний усны шугам, зам талбайн борооны ус зайлуулах шугамаас хамгаалалтын зурвас авч төлөвлөлт гүйцэтгэх; - ажлын зураг батлагдсан үерийн хамгаалалтын байгууламжийн трассыг тусгах; - урт, дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүдийн хүрээнд төлөвлөгдсөн голын эргийн хамгаалалтын далан, урсац тохируулгын усан сангийн ажлын зураг төслийг төлөвлөлтөд тусгах; - төлөвлөгдсөн байршилд судалгаа, инженер геологи, гидрогеологи, гидрологийн тооцоо судалгаа хийж, хөрсний усны түвшин доошлуулах шүүрүүлийн байгууламж, зам талбайн борооны ус зайлуулах шугам сүлжээ төлөвлөлтийн тооцооллыг нарийвчлах; - болзошгүй үерийн аюулыг 1. 5. 10%-ийн хангамшлын зарцуулалтыг тодорхойлж, үерийн зардлыг 1%-ийн хангамшлаар тооцох;

		- хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн зорчих зам, талбайг норм, стандартын дагуу төлөвлөх; - барилга байгууламжийг төлөвлөхдөө орчин үеийн дэвшилтэд технологийг тусгасан ухаалаг, байгаль орчинд ээлтэй шийдэлтэй байх; **Дулаан хангамж:** - дулааны станцаас тэжээгдэж буй дулаан хангамжийн сүлжээнээс хангагдах бүсүүдийн төлөвлөлтийн хүн амын нягтралыг шугам сүлжээний хүчин чадалтай уялдуулан төлөвлөх; - дулаан хангамжийн сүлжээний одоогийн байдлын судалгааг гаргаж, төлөвлөлтийн хүчин чадлыг тооцох; - төлөвлөлтийн бүсэд өндрийн түвшингийн зөрүүгээр нэгдсэн дулаан хуваарилах төв төлөвлөж төлөвлөлтийг архитектур орон зайн төлөвлөлтөд тусгах; - дулаан хангамжийн хэрэглээний тооцоо, цаашид нэмэгдэх ачааллыг тооцоолох; - цаашид өсөн нэмэгдэх хэрэглээний ачааллыг тооцох, хэрэглээг хангах эх үүсвэрийг төлөвлөх; - эрчим хүчний 20%-ийн хэрэглээг сэргээгдэх эрчим хүчээр хангахаар төлөвлөх; - дулааны эх үүсвэрийг нүүрс, цахилгаан, устөрөгч, газрын гүний дулаан, нар салхины эрчим хүч, шингэрүүлсэн хийгээр хангах боломжийн талаарх зөвлөмж харьцуулсан судалгаа хийж харьцуулах, анхны хөрөнгө оруулалт, ашиглалтын зардал, агаарын бохирдлын хэмжээ зэрэг харьцуулсан судалгаа гаргах; - эдийн засгийн үр ашигтай, байгаль орчинд сөрөг нөлөөлөл бага, шинэ технологийн эх үүсвэртэй байх; - дулааны эх үүсвэрүүдийн ашигт үйлийн коеффициент нь 85 хувиас дээш байх /Дулааны эх үүсвэрийн дотоод хэрэгцээ, цахилгаан зарцуулалт нь хамгийн бага байх хувилбар, технологийг дэвшүүлсэн байх/; - дулааны станц руу 2 эгнээ бүхий 2 талын орц, гарцтай хатуу хучилттай зам, нормын зогсоол төлөвлөх. **Усан хангамж:** - хүн амын унд-ахуйн ус хангамжийг Мянганы сорилтын сангийн II компакт гэрээгээр хэрэгжиж ашиглалтад орох "Баруун" эх үүсвэрээс цэвэр усаар хангагдах боломжтой . "Баруун" эх үүсвэрийн ус гүн цэвэршүүлэх үйлдвэрээс гарч буй шугамаас холболт авах гол түгээх шугамыг барьж байгуулсанаар Улаанбаатар хотын баруун хэсгийн Жаргалант, 361-н гарам, Аргалант эмээлт, Монгол наадам зэрэг олон суурьшил тосгоныг цэвэр усаар найдвартай хангах

		боломж бүрдэнэ 2025 он хүртэл бие даасан эх үүсвэрийг ашиглана. Хувийн хэрэгцээний гүний худгуудын усанд шинжилгээ хийж, эрүүл ахуйн хамгаалалтын дэглэмийг мөрдүүлнэ. - төвлөрсөн шугам сүлжээнээс хангагдах тохируулах усан сан, насос станц, дамжуулах сүлжээг байршил тус бүр тусгах шаардалагатай **Ариутгах татуурга:** - одоо байгаа төмөр замаар хуваагдан байрласан, мөн тосгод хооронд зай талбай харьцангуй их учир хэрэглэгчдээс гарах бохир усыг бие даасан, хэсэгчилсэн байдлаар цэвэрлэх байгууламж төлөвлөх; - 2025 оны богино хугацаанд хэрэглэгчдээс гарах бохир усыг ариутгалын тоног төхөөрөмж буюу био болон эко жорлон ашиглахаас гадна бие даасан бохир усны цооног, септик системийг ашиглах боломжтой. **Цахилгаан хангамж:** - цахилгаан хангамжийн ачааллыг батлагдсан норм дүрмийн дагуу тооцох. - цахилгаан хангамжийн одоогийн байдлын судалгааг гаргах. - хуваарилах байгууламж болон хаалттай дэд өртөөнүүдийн хүчин чадалтай уялдуулж төлөвлөх, - Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 97 дугаар тогтоолоор баталсан Цахилгаан эрчим хүч хэрэглэх дүрэм, Эрчим хүчний шугам сүлжээг хамгаалах дүрмийг баримтлан төлөвлөх, - төлөвлөлтийн ачаалалд зам талбайн гэрэлтүүлэг, хамгаалалт болон бусад нийтийн эзэмшлийн хэрэглээний тог цахилгааны ачааллыг тооцон тусгах, - цаашид өсөн нэмэгдэх хэрэглээний ачааллыг тооцох, хэрэглээг хангах эх үүсвэрийг төлөвлөх. - төлөвлөлтийн цахилгаан хангамжид төлөвлөх дэд станц, цахилгаан дамжуулах агаарын шугам, цахилгаан дамжуулах кабель шугамын төлөвлөлтөд цахилгаан эрчим хүчээр хангагч байгууллагаас санал авч тусгах, хянуулах. **Мэдээлэл холбоо, дохиолол:** - МХС ХХК худаг сувагчлалын байгууламжаас алслагдсан хэсэгт агаарын баганат шугамаар дамжуулах сүлжээг төлөвлөнө. Агаарын баганат шугамын хоорондын зай 60 м-ээс хэтрэхгүй байна; - төлөвлөлтийн бүсэд барилга байгууламж бүрийг худаг сувагчлалын байгууламжаар холбож цагираг сүлжээ үүсгэхээр төлөвлөнө. Байршлаас хамаарч 2-4 эгнээ яндантай сувагчлал хийхээр төлөвлөх; - төлөвлөлтийн бүсийн барилга байгууламж дотор техникийн өрөө төлөвлөнө. Өрөөнд суурин

		холбооны дэд станц /MSAN/ болон интернетийн төгсгөлийн төхөөрөмж байршуулж түүнээс цааш хэрэглэгчид түгээнэ; - төлөвлөлтийн бүсэд үүрэн холбооны утасгүй сүлжээ төлөвлөх.
15.	Онцгой нөхцөл	- Хот, суурин газрын орон зайн төлөвлөлтийг боловсруулахдаа 20 минутын хот концепцид нийцүүлэн боловсруулж, иргэд олон нийтэд танилцуулж, үйлчилгээний төрлийг тодорхойлох. - Дагуул хотын 9000 га талбайд нарийн ногоо, далайн гаралтай бүтээгдэхүүн, мөөг, хөнгөн үйлдвэрлэлийн чиглэлийн Эдийн засгийн тусгай бүсийн ерөнхий төлөвлөлтийг гаргах. - Олон улсын газар тариалан, хүлэмжийн аж ахуйн чиглэлийн эдийн засгийн тусгай бүс, сэргээгдэх эрчим хүч, усны нөөцийн ухаалаг менежмент бүхий агро паркуудын туршлага судлан өөрийн орны цаг уурын онцлогт тохируулан нутагшуулах боломжийг судлан төлөвлөлтөд тусгах. - Эдийн засгийн тусгай бүсийн төлөвлөлтөд гадаад дотоодын хөрөнгө оруулалтыг татах таатай орчныг бүрдүүлсэн, экспорт импортыг дэмжих, нарийн ногоо, мөөг, далайн гаралтай бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийг хөгжүүлэх, техник технологийг нутагшуулах, эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэх төлөвлөлтийн зарчмуудыг тусгасан байх. - Баримт бичиг нь орчин үеийн хотжилтын чиг хандлага, шийдэлд нийцсэн, шинэлэг байх. - Олон улсад амжилттай байгуулж хөгжүүлсэн дагуул хот, эдийн засгийн тусгай бүсийн туршлагатай харьцуулах, авч хэрэгжүүлэх боломжтой сайн туршлагыг тодорхойлсон байх. - Тухайн байршилд батлагдсан ХЕТ, болон барилгажилтын төслийн уялдаа холбоог хангасан байх. - Төлөвлөлт нь иргэдийн эрүүл мэнд, амь нас, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчинд аюулгүй, тогтвортой байх. - Хөдөө аж ахуй, газар тариалангийн чиглэлээр үйлдвэрүүд, ухаалаг хүлэмж, дөрвөн улирлын хүлэмжийн байгууламжийг нутагшуулах боломжит нөхцөлийг судлан тусгах. - Ерөнхий төлөвлөгөө боловсруулах явцад ажлын даалгаварт тусгагдаагүй, орхигдсон ажлыг тухай бүрд нь тодорхойлох, тусгах. - Шаардлагатай тохиолдолд гүйцэтгэгч шалгарсны дараа зургийн даалгаварт өөрчлөлт оруулна. - Дэд бүтэц, инженерийн шугам сүлжээний хамгаалалтын зурвасыг ерөнхий төлөвлөгөөнд тусгах.

		- Хамгаалалтын зурваст өртсөн нэгж талбар, газар чөлөөлөлтийн зардлыг хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнд тусгах.

ЗӨВШӨӨРСӨН:

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Д. АМГАЛАН

НИЙСЛЭЛИЙН ЕРӨНХИЙ АРХИТЕКТОР Ч.ТӨГСДЭЛГЭР

ХОТ БАЙГУУЛАЛТ, ХОТЫН СТАНДАРТЫН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Г.БАЯРСАЙХАН

АГРО-СИТИ ЭДИЙН ЗАСГИЙН ТУСГАЙ БҮСИЙН ЗАХИРАГЧ Г.БАТБАЯР

ХЯНАСАН:

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН НИЙСЛЭЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН ГАЗРЫН ДАРГА Д.ХАДБААТАР

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ХУУЛЬ ТОГТООМЖ, ГЭРЭЭ, ЭРХ ЗҮЙН ГАЗРЫН ДАРГА М.ҮНЭНБАТ

ХОТ БАЙГУУЛАЛТ, ХОТЫН СТАНДАРТЫН ГАЗРЫН ЕРӨНХИЙ АРХИТЕКТОРЫН АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА А.БАТТӨМӨР

ХОТ БАЙГУУЛАЛТ, ХОТЫН СТАНДАРТЫН ГАЗРЫН ДЭД ТӨВ, ДАГУУЛ ХОТЫН ХӨГЖЛИЙН ХЭЛТСИЙН ДАРГА Ч.БАДАМХАНД

ХОТ БАЙГУУЛАЛТ, ХОТЫН СТАНДАРТЫН ГАЗРЫН БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА С.ДАЛАНЖАРГАЛ

ХОТ БАЙГУУЛАЛТЫН ИНЖЕНЕРИЙН ДЭД БҮТЦИЙН ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Ц.ЛХАМСҮРЭН

БОЛОВСРУУЛСАН:

ХОТ БАЙГУУЛАЛТ, ХОТЫН СТАНДАРТЫН ГАЗРЫН ДЭД ТӨВ, ДАГУУЛ ХОТЫН ХӨГЖЛИЙН ХЭЛТСИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН М.АМАРЗАЯА

ТӨЛӨВЛӨЛТИЙН БАЙРШЛЫН ЭРГЭЛТИЙН ЦЭГИЙН СОЛБИЦОЛ
/АГРОСИТИ ДАГУУЛ ХОТ/

Байршил	Талбайн хэмжээ /га/	Цэгийн дугаар	Уртраг	Өргөрөг
Сонгинохайрхан дүүрэг, 21 дүгээр хороо	24294.7 га	1	106 º 36' 46.0972497924 "	47 º 58' 5.46966895224 "
		2	106 º 36' 26.9567806104 "	47 º 57' 23.486319558 "
		3	106 º 36' 15.5862794484 "	47 º 56' 51.81076453092 "
		4	106 º 36' 15.3522430668 "	47 º 56' 50.01789552468 "
		5	106 º 35' 58.4723452308 "	47 º 56' 42.01615392648 "
		6	106 º 35' 27.941074062 "	47 º 56' 49.47665279928 "
		7	106 º 35' 9.7867448232 "	47 º 56' 56.70569079384 "
		8	106 º 35' 3.9666856128 "	47 º 56' 49.27140834144 "
		9	106 º 34' 48.744202332 "	47 º 56' 47.870902122 "
		10	106 º 34' 35.8850579664 "	47 º 56' 45.3638717268 "
		11	106 º 34' 23.6456933412 "	47 º 56' 36.94359877764 "
		12	106 º 34' 9.1418170152 "	47 º 56' 32.8479910998 "
		13	106 º 33' 53.5485175668 "	47 º 56' 19.10505116724 "
		14	106 º 33' 39.990532518 "	47 º 56' 19.82636972592 "
		15	106 º 33' 19.4714126568 "	47 º 56' 28.15622813148 "
		16	106 º 33' 3.5651966076 "	47 º 56' 30.51842617752 "
		17	106 º 32' 45.5829821304 "	47 º 56' 43.64314375776 "
		18	106 º 32' 23.3499319152 "	47 º 56' 48.23595906 "
		19	106 º 32' 12.5352804768 "	47 º 57' 0.7262812476 "
		20	106 º 31' 49.0821499272 "	47 º 57' 20.07644389524 "
		21	106 º 31' 41.7898240608 "	47 º 57' 18.57033813312 "
		22	106 º 31' 38.5000037688 "	47 º 57' 18.29999815308 "
		23	106 º 31' 21.2206767348 "	47 º 57' 27.89544414096 "
		24	106 º 29' 32.6209997256 "	47 º 58' 28.84799972928 "
		25	106 º 29' 32.4784434912 "	47 º 58' 28.24254425784 "
		26	106 º 28' 51.7999997856 "	47 º 58' 50.800002807 "
		27	106 º 27' 33.2000007156 "	48 º 0' 4830000169140 "
		28	106 º 27' 37.8509421852 "	48 º 1' 58625762309040 "
		29	106 º 28' 17.3989686828 "	48 º 1' 51862909035720 "
		30	106 º 28' 34.913996436 "	48 º 2' 3857597592720 "
		31	106 º 29' 22.0025589252 "	48 º 2' 16399104401040 "
		32	106 º 29' 38.9724681588 "	48 º 2' 5868192218640 "
		33	106 º 30' 8.0593580484 "	48 º 2' 26228424348960 "
		34	106 º 30' 19.6208575092 "	48 º 2' 283632534060 "
		35	106 º 30' 5.9166498744 "	48 º 3' 353288382480 "
		36	106 º 30' 1.9005148332 "	48 º 3' 129485090880 "
		37	106 º 29' 58.1302734072 "	48 º 3' 1866908591640 "

		38	106 º 29' 24.7836570396 "	48 º 3' 46789137244440 "
		39	106 º 29' 34.9950234408 "	48 º 3' 51382910195640 "
		40	106 º 29' 39.380847342 "	48 º 3' 50460260509440 "
		41	106 º 29' 52.921520772 "	48 º 4' 60366105660 "
		42	106 º 30' 13.5268959744 "	48 º 3' 59343553590120 "
		43	106 º 30' 49.735363896 "	48 º 4' 40504069661880 "
		44	106 º 31' 16.7086665984 "	48 º 4' 51852725746680 "
		45	106 º 31' 23.8479837564 "	48 º 4' 505678016640 "
		46	106 º 31' 28.3233881496 "	48 º 4' 5178667464120 "
		47	106 º 31' 40.3514086656 "	48 º 4' 4622350516140 "
		48	106 º 31' 59.4185153916 "	48 º 4' 58862744456520 "
		49	106 º 32' 58.6968732456 "	48 º 5' 29356127292480 "
		50	106 º 33' 44.2978199064 "	48 º 5' 24624915642240 "
		51	106 º 34' 19.187161878 "	48 º 6' 3644436093840 "
		52	106 º 34' 22.1919563532 "	48 º 6' 2320164517360 "
		53	106 º 34' 58.603484514 "	48 º 6' 23877870874920 "
		54	106 º 35' 1.8464147592 "	48 º 6' 10590137371440 "
		55	106 º 35' 14.7006964716 "	48 º 6' 7538556199320 "
		56	106 º 35' 22.112387664 "	48 º 6' 12389725546560 "
		57	106 º 35' 40.3201051368 "	48 º 6' 1716696938880 "
		58	106 º 35' 48.3023782176 "	48 º 6' 10006457943240 "
		59	106 º 36' 12.4048461924 "	48 º 6' 15272108777880 "
		60	106 º 37' 5.5486302672 "	48 º 6' 49192590342960 "
		61	106 º 37' 53.2391152548 "	48 º 6' 57453854202720 "
		62	106 º 38' 12.8852262384 "	48 º 7' 15015017399880 "
		63	106 º 36' 51.6361139532 "	48 º 7' 3653552804160 "
		64	106 º 36' 47.428539048 "	48 º 7' 48050362699320 "
		65	106 º 37' 0.5800473336 "	48 º 8' 4146082128960 "
		66	106 º 37' 19.4873688948 "	48 º 8' 12194306170440 "
		67	106 º 37' 11.9366809644 "	48 º 8' 197917977480 "
		68	106 º 36' 0.494348994 "	48 º 8' 4468845566580 "
		69	106 º 35' 24.427654548 "	48 º 9' 46105377240960 "
		70	106 º 35' 48.7170858156 "	48 º 10' 6.32927949744 "
		71	106 º 39' 29.7302728788 "	48 º 9' 4710665712780 "
		72	106 º 40' 3.1707364008 "	48 º 11' 53.05372522764 "
		73	106 º 37' 5.2100796072 "	48 º 11' 41.48680610832 "
		74	106 º 36' 30.2837132808 "	48 º 10' 48.31465298916 "
		75	106 º 36' 8.1652582692 "	48 º 10' 48.2213151264 "
		76	106 º 34' 53.0388326172 "	48 º 11' 36.7054590498 "
		77	106 º 34' 20.0524402452 "	48 º 13' 29.29439960436 "
		78	106 º 36' 43.3487405052 "	48 º 13' 55.6713122268 "
		79	106 º 39' 30.4990323804 "	48 º 14' 15.12035214504 "
		80	106 º 40' 35.9278857948 "	48 º 13' 54.32409865812 "
		81	106 º 44' 42.277441092 "	48 º 13' 40.26869850036 "
		82	106 º 46' 7.9844264472 "	48 º 13' 29.2758060954 "
		83	106 º 45' 31.4866539324 "	48 º 12' 50.83342026516 "

		84	106 º 44' 15.9973591632 "	48 º 12' 23.535300825 "
		85	106 º 43' 23.378208096 "	48 º 10' 46.57383244452 "
		86	106 º 42' 59.3778082896 "	48 º 10' 10.69567922388 "
		87	106 º 42' 53.7853868856 "	48 º 10' 5.76839774028 "
		88	106 º 42' 29.383826886 "	48 º 9' 46887541348680 "
		89	106 º 42' 14.7045211956 "	48 º 9' 3301720433460 "
		90	106 º 42' 9.9578158668 "	48 º 9' 21115746370440 "
		91	106 º 42' 10.115465544 "	48 º 8' 5371828793340 "
		92	106 º 42' 0.5461547544 "	48 º 8' 30755182970760 "
		93	106 º 41' 49.010192718 "	48 º 8' 22629915500640 "
		94	106 º 40' 53.0186713284 "	48 º 7' 3717914874060 "
		95	106 º 40' 35.090767776 "	48 º 7' 14231981634960 "
		96	106 º 39' 17.1298281888 "	48 º 6' 4316435663580 "
		97	106 º 38' 33.3764861136 "	48 º 6' 19363378431960 "
		98	106 º 38' 10.7587171608 "	48 º 5' 53123422026840 "
		99	106 º 37' 21.9720413676 "	48 º 5' 11189368578120 "
		100	106 º 36' 40.6324305 "	48 º 4' 5804844892860 "
		101	106 º 35' 31.1999833608 "	48 º 4' 2070001134840 "
		102	106 º 35' 11.6369670192 "	48 º 4' 8140981736280 "
		103	106 º 35' 24.342 "	48 º 2' 590300160 "
		104	106 º 34' 37.25184 "	48 º 2' 25622015999640 "
		105	106 º 35' 42.79596 "	48 º 1' 43259015999640 "
		106	106 º 34' 44.8833326484 "	48 º 1' 3486629449920 "
		107	106 º 35' 5.9909938188 "	48 º 0' 47468660505120 "
		108	106 º 35' 30.7028569416 "	48 º 0' 37363638117960 "
		109	106 º 35' 49.1594230932 "	48 º 0' 20396286857160 "
		110	106 º 36' 16.7608680768 "	48 º 0' 30834003330720 "
		111	106 º 36' 39.9579343344 "	48 º 0' 13228686629640 "
		112	106 º 35' 54.6683555184 "	47 º 59' 48.13231699644 "
		113	106 º 37' 40.66968405 "	47 º 58' 38.36046580284 "
		114	106 º 36' 46.0972497924 "	47 º 58' 5.46966395224 "

ТӨЛӨВЛӨЛТИЙН БАЙРШЛЫН ЭРГЭЛТИЙН ЦЭГИЙН СОЛБИЦОЛ
/АГРОСИТИ ЭДИЙН ЗАСГИЙН ТУСГАЙ БҮС/

Дүүргийн нэр	Солбицол			Талбайн хэмжээ
	Цэгийн дугаар	Өргөрөг	Уртраг	
Сонгино хайрхан дүүрэг	1	106° 42' 3.366" E	48° 13' 49.160" N	9,000 га
	2	106° 44' 42.277" E	48° 13' 40.269" N	
	3	106° 46' 7.984" E	48° 13' 29.276" N	
	4	106° 45' 31.487" E	48° 12' 50.833" N	
	5	106° 44' 15.997" E	48° 12' 23.535" N	
	6	106° 43' 23.378" E	48° 10' 46.574" N	
	7	106° 43' 12.618" E	48° 10' 31.223" N	
	8	106° 42' 59.378" E	48° 10' 10.696" N	
	9	106° 42' 53.785" E	48° 10' 5.768" N	
	10	106° 42' 29.384" E	48° 9' 46.888" N	
	11	106° 42' 14.705" E	48° 9' 33.017" N	
	12	106° 41' 57.874" E	48° 8' 50.810" N	
	13	106° 41' 18.915" E	48° 8' 23.450" N	
	14	106° 40' 23.639" E	48° 8' 51.901" N	
	15	106° 40' 18.583" E	48° 9' 6.465" N	
	16	106° 39' 49.958" E	48° 9' 19.477" N	
	17	106° 39' 33.536" E	48° 9' 1.140" N	
	18	106° 39' 1.959" E	48° 9' 3.911" N	
	19	106° 38' 48.750" E	48° 8' 50.382" N	
	20	106° 39' 35.778" E	48° 8' 26.121" N	
	21	106° 39' 37.307" E	48° 7' 56.003" N	
	22	106° 38' 49.775" E	48° 7' 55.065" N	
	23	106° 38' 36.598" E	48° 8' 9.895" N	
	24	106° 37' 23.915" E	48° 8' 7.738" N	
	25	106° 37' 11.937" E	48° 8' 19.792" N	
	26	106° 36' 0.494" E	48° 8' 44.688" N	
	27	106° 35' 24.428" E	48° 9' 46.105" N	

	28	106° 35' 48.717" E	48° 10' 6.329" N	
	29	106° 39' 29.730" E	48° 9' 47.107" N	
	30	106° 40' 3.171" E	48° 11' 53.054" N	
	31	106° 37' 5.210" E	48° 11' 41.487" N	
	32	106° 36' 30.284" E	48° 10' 48.315" N	
	33	106° 36' 8.165" E	48° 10' 48.221" N	
	34	106° 34' 53.039" E	48° 11' 36.705" N	
	35	106° 34' 20.052" E	48° 13' 29.294" N	
	36	106° 36' 43.349" E	48° 13' 55.671" N	
	37	106° 39' 30.499" E	48° 14' 15.120" N	
	38	106° 40' 35.928" E	48° 13' 54.324" N	
	39	106° 42' 3.366" E	48° 13' 49.160" N	

АГРОСИТИ ДАГУУЛ ХОТЫН БАЙРШЛЫН СХЕМ



ХӨГЖЛИЙН ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТООН ЗУРГИЙГ МЭДЭЭЛЛИЙН САНД ХҮЛЭЭН АВАХАД ТАВИГДАХ ШААРДЛАГА

1. Солбицлын тогтолцоо: *WGS84-UTM*
2. Мэдээллийн санд хүлээлгэн өгч байгаа ерөнхий төлөвлөгөөний тоон зургийг 1:10000 харьцаагаар зурж, **.dwg. *.shp* өргөтгөлтэй бэлтгэнэ.
   - *Төлөвлөж буй хот байгуулалтын бүсчлэл тус бүрийн зориулалт, хучин чадал, давхар талбайн харьцаа, барилга бүрхэцийн талбай, бүсийн нийт талбай, барилгажих талбай, хүн ам, орон сууцны нягтрал, давхрын хязгаар мэдээллүүдийг *.shp* өргөтгөлтэй бэлтгэн хүлээлгэж өгнө.
   - **.dwg. /polyline, polygon, point/, /Хүснэгт 1: Auto CAD программын ХЕТ-ний давхаргын стандарт/*
   - **.shp /area, polyline, point, line/,/Хүснэгт 2: QGis программын ХЕТ-ний давхаргын стандарт/*

3. Байр зүйн тоон зургийг суурь болгон ашиглахдаа байр зүйн зургийн батлагдсан заавар, стандартыг баримтална.

   /Хүснэгт 3: Байр зүйн зургийн давхаргын стандартыг хавсаргав/

Мэдээллийн санд ерөнхий төлөвлөгөөний тоон зураг хүлээлгэн өгөх материал

1. Стандартын дагуу хийж гүйцэтгэсэн ерөнхий төлөвлөгөөний зургийг тоон хэлбэрээр */*.dwg, *.shp, *.jpg, Sketch UP, 3d max файл/* хүлээлгэн өгнө. */CD-5 хувь/*
2. Ерөнхий төлөвлөгөөг зөвшөөрөлцсөн, баталсан албан тушаалтны гарын үсэг болон зураг хийж гүйцэтгэсэн компанийн тамга, гарын үсэгтэй хэвлэмэл зураг.

БАЙР ЗҮЙН ЗУРГИЙН ДАВХАРГЫН СТАНДАРТ

/Хүснэгт 1/

Д/д	layer-ийн бичиглэл	Тайлбар	Color /Өнгө/	Linetype /Зураасны төрөл/	Lineweight /Зураасны өргөн/	Таних тэмдэг
1	1	Байшин, барилга	White /үндсэн цагаан/	Continuous /үргэлжилсэн/	0.00	
